

СЭТГҮҮЛ ЗҮЙН “ДӨРӨВ ДЭХ ЗАСАГЛАЛ”:
ТҮҮХЭН ҮНДЭС, МӨН ЧАНАР, ОРЧИН ҮЕИЙН ХАНДЛАГА

М. Зулькафиль*

* МУИС, НШУС, Сэтгүүл зүйн тэнхмийн эрхлэгч, шинжлэх ухааны доктор (Sc.D.), профессор,
Монгол Улсын Соёлын гавьяат зүтгэлтэн

Түлхүүр үг: мэдээллийн нийгэм, соёлын үнэт зүйлс, “дөрөв дэх давхарга”, цахим мэдээлэл харилцааны хувьсгал, мэдээллийн объектив шинж

Орчин үеийн нийгмийг янз бүрийн шинж чанарын тусламжтайгаар даяарчлагдсан, мэдээллийн, мэдээлэл харилцааны нийгэм зэргээр тодорхойлсон байдаг. Энэхүү олон янзын тодорхойлолтуудын дотор мэдээлэл түгээх шинжийг хамгийн гол, үндсэн шинж гэж үзсэн байдаг. Тиймээс бидний дээр дурдсан мэдээллийн, мэдээллийн харилцааны нийгэм хэмээх тодорхойлолтыг маш өргөн хэрэглэх хандлага ажиглагдаж байна. Мэдээлэл харилцааны нийгэм хэмээх ойлголтыг Английн судлаач Жон Б. Томпсон «Медиа ба модернити» (1915) бүтээлд институтчлагдан зохион байгуулагдсан нэгдлүүдийн үүргийг тодорхойлох зорилгоор анх хэрэглэсэн түүхтэй. Судлаач тийм нэгдлийн нэгээр ОНМХ-үүдийг нэрлэж, тэдний үүрэг зөвхөн мэдээлэл түгээх төдийгүй, сүүлчийн хэдэн зуун жилийн туршид орчин үеийн нийгмийг төлөвшүүлэгч соёлын хэм хэмжээ, үнэт зүйлсийг түгээн дэлгэрүүлэхэд оршино гэж дүгнэсэн байдаг¹. Энэ үүргийг мэргэжсэн сэтгүүлчид гүйцэтгэдэг бөгөөд тэд орчин үед зөвхөн мэдээллийг түгээгчид бус, нийгмийн санаа бодлыг бүрдүүлэгчид юм. Тиймээс тэдний ний-

гэмд үзүүлж буй үйл ажиллагааны нөлөөллийг засаглалын төрлүүдтэй харьцуулах замаар «Дөрөв дэх засаглал» гэж нэрлэсэн байдаг.

Ер нь энэ ойлголт бол шинэ зүйл биш, хоёр зуу гаруй жилээс олон нийтэд танил болж эхэлсэн түүхтэй юм. Гэхдээ орчин үед сэтгүүлчид, судлаачдын сэтгүүл зүйн «дөрөв дэх засаглал»-ын тухай ойлголт хараахан нэг мөр болоогүй, түүнийг янз бүрээр, өөрсдийн үзэмжээр тайлбарлах явдал ч түгээмэл юм. Тиймээс ОНМХ засаглалын үүргийг биелүүлэхэд нийгмийн зүгээс нөлөөлөх хүчин зүйлсийг мэдэх, сэтгүүл зүй ба нийгмийн хоорондох харилцаа холбоо, үйл явцын утга учрыг гүнзгий ойлгох нь урьдын адил судлахыг шаардсан асуудал хэвээр байна. Энэ асуудлыг судлахын тулд юуны өмнө дээрх ойлголтын үүсэл болон агуулгын талаар арай дэлгэрэнгүй авч үзэх шаардлагатай юм.

«Дөрөв дэх засаглал» хэмээн ойлголт бүр ХVIII зуунд Британид үүсчээ. Тухайн үед анхны мэдээллийн хэрэгсэл болох сонины нийгэм дэх ач холбогдлыг илэрхийлж байсан бөгөөд хэвлэн нийтлэгчид, зохион байгуулагчид зөвхөн өөрсдийн уншигчдад мэдээлэл түгээхээс гадна тэдний иргэний ашиг сонирхол, эрх чөлөөг төрийн зүгээс үзүүлэх аливаа дарамт шахалтаас хамгаалах зорилго тавьж байжээ.

Энэ хандлагын ач холбогдол нь аажим аажмаар нэмэгдэж, бусад гурван давхаргын үйл ажиллагаатай эн зэрэгцэх төвшинд хүрчээ.

Түүхэн дэх хамгийн анхны олон нийтийн мэдээллийн хэрэгсэл болох тогтмол хэвлэлийн үйл ажиллагааны гол үндэс нь үг хэлэх эрх чөлөөний зарчим байв. Энэ зарчим төр засаг болон нийгмийн хоорондох байр суурийг илэрхийлдэг тулгамдсан асуудлуудыг агуулдаг талбар болон хувирч, харин төр, нийгмийн хоорондох харилцааны гол тулгуур багана нь сонин хэвлэл болж байжээ.

ОНМХ-ийн үүргийн тухай, ялангуяа улс төрийн үүргийн тухай маргаан бол XYII-XIX зууны үед чөлөөт хэвлэлийн тухай үзэл санааг хэрэгжүүлэхийн төлөөх тэмцлийн үед үүссэн хандлагуудын хамгийн гол шинжүүдийг агуулж буй нь ажиглагддаг. Энэхүү чөлөөт хэвлэлийн төлөө тэмцлийн үр дүнд яг энэ үед Англи ба АНУ-д иргэний нийгэм төлөвшсөн түүхтэй юм. Германы нэрт философич Ю.Хабермасын дүгнэлтээр Европын түүхэнд энэ үед үүсэж бий болсон иргэний нийгмийн урьдач нөхцөл бол «олон нийтийн хүрээ»² хэмээн нэрлэгддэг хүмүүсийн цоо шинэ нэгдэл байжээ. Олон нийтийн хүрээ бол хатуу хяналт бүхий төвлөрсөн засаглалын эсрэг чиглэгдсэн олон нийтийн бие даасан бүлэглэлүүдийн нэгдэл байв. Энэ бол эдийн засгийн эрс өсөлтийн нөхцөл дэх өргөн хүрээг хамарсан хувийн сектор ба төр засгийн хоорондох өвөрмөц орон зай байжээ. Олон нийтийн чөлөөт маргаан, өргөн хэлэлцүүлгийн талбар болсон энэхүү шинэ хүрээний гол онцлог нь олон нийтийн санаа бодлыг бүрдүүлэхэд чиглэгдэж байв. Судлаачид энэ хандлагыг XYIII зууны үед үүссэн гэж үздэг бөгөөд гол зорилго нь тухайн үеийн «өөрөө өөрийгөө удирдах» засгийн газрыг хянахад оршиж байв.

Энэхүү олон нийтийн хүрээнд «нийгмийн сэтгэх чадвартай» хэсэг болох бүлэг нь нийгмийн санаа бодлыг

хөгжүүлэх оновчтой арга замын талаарх өөрсдийн үзэл бодлыг хамт олноороо, адил төвшинд хэлэлцэхийг зорилго болгож, төр засгийн өмнө олон нийтийн үзэл бодлыг илэрхийлэгч, хамгаалагчийн үүргийг хүлээсэн сонин хэвлэлээр дамжуулан төрийн бодлогод нөлөөлдөг байжээ. Хэвлэлийн энэ үүрэг нь нэг талаар, олон нийтийн маргаан мэтгэлцээний орон зайг бий болгох, тийм маргаан өрнүүлэх боломжоор хангах, нөгөө талаар сонины хуудсаар дамжуулан иргэдийн үзэл бодлыг төр засагт хүргэх зэрэг нэгдмэл хоёр зорилтыг нэгэн зэрэг гүйцэтгэж байснаараа онцлогтой юм. Үүний үр дүнд олон нийт ба төр засгийн хооронд нэг ёсны зөвшөлцлийг төлөвшүүлэх үндэс суурь бий болж, засаглалын орон зайг аажим аажмаар өөрчлөх замаар төр засгийн нөлөөллийн хүрээг мэдэгдэхүйц багасгаж, түүний нийгэмд үзүүлэх нөлөө нь ихээхэн суларч эхэлжээ. Өөрөөр хэлбэл, ийм замаар Ю.Хабермасын загварын дагуу XYII зуунаас эхлэн иргэний нийгэм төлөвших үйл явц өрнөсөн бөгөөд чөлөөт өрсөлдөөн, хувь хүний эрх чөлөөний хамт сонгодог либерализмын гурван тулгын чулууны нэг болсон түүхтэй юм.

Либерализмын нийгэм-гүн ухааны үзэл баримтлал нь үгийн болон хэвлэлийн эрх чөлөөг эрхэмлэн дээдэлж, түүнд онцгой ач холбогдол өгч байсан Английн сэтгэгчид болох яруу найрагч Жон Мильтон, гүн ухаантан Жон Локк, Иеремия Бентам, Жон Стюарт Миллийн үзэл санаанаас эхтэй юм. Англид хэвлэлийн эрх чөлөөний үзэл санааны тухай онолын үндэслэл нь анх XYII зууны дунд үед энэ талаар дэвшүүлэн Жон Мильтоны (1608-1674) теологийн шинжтэй үзэл баримтлалтай холбоотой гарч ирсэн юм. Түүний логик нь маш энгийн. Бурхан хүн болгонд оюун ухаан, бие дааж сэтгэн бодох чадвар заяаж, унших боломж олгосон учраас хэвлэлийн эрх чөлөөг хязгаарлах нь хүн христиан хүн шиг амьдрах боломжгүй

болгоно. Цагдан хяналт, хязгаарлалт бол дээр дурдсан бурхнаас заяагдсан боломжтой зөрчилдөж, хүн өөрийнхөө хүн чанарт үндэслэгдсэн сайн ба муугийн хооронд бие дааж сонголт хийх боломжийг хязгаарлах болно гэсэн санаа юм.

Орчин үед түгээмэл хэрэглэдэг «үзэл бодлын зах зээл», «үнэнд эргэж ирэх үйл явц» зэрэг ойлголт чухамхүү Мильтоноос эхтэй бөгөөд «Хэлэх юмтай хүн болгон өөрийгөө илэрхийлэх эрх чөлөө эдэлж байг... Төр засаг энэ тэмцэлд (үзэл бодлын) оролцох, аль нэг талын давуу тал, боломжид нөлөө үзүүлэх ёсгүй. Худал хуурмаг үзэл бодол хүртэл түр хугацааны ялалтанд хүрч болно. Аливаа үнэн зүйл өөрийгөө хамгаалах хүч нэмж, эцсийн эцэст үнэнд эргэж ирэх замаар л амьдрал чадвартай»³ юм.

Хэвлэлийн эрх чөлөө бол бие хүний жам ёсны эрхээс урган гарсан гэсэн үзэл санааны үндэслэлийг Жон Локк (1632-1704) Мильтоны дүгнэлтийг баяжуулан хөгжүүлэх замаар дэвшүүлжээ. Локкийн дүгнэлтээс үзэхэд хүн төрөлхийн итгэл үнэмшилтэй байх жам ёсны эрх эдэлдэг учраас засаглалын төв нь төр засаг биш, ард түмний эрх ашиг байдаг ажээ. Тиймээс хүн өөрийн жам ёсны эрхийг төрийн хүсэл зорилгыг үл харгалзан хэрэгжүүлэх эрх чөлөөтэй бөгөөд тийм жам ёсны, халдашгүй эрхийн нэг бол хэвлэлийн эрх чөлөө мөн. Үүнээс гадна хэвлэлийн эрх чөлөө төрийн засаглалд эерэг нөлөө үзүүлдэг. Өөрөөр хэлбэл, парламентын худал хуурмаг үйл ажиллагаа, засгийн газрын бүхнийг захирах гэсэн оролдлогын эсрэг зогсож, сайн засаглалтай болоход нөлөөлдөг байна. Локкийн бодлоор хэвлэлийн эрх чөлөө хэрэгжих явцад хуулийг эрхэмлэн дээдэлдэг нийгэм аажим аажмаар төлөвших болно.

Сүүлд хэвлэлийн эрх чөлөөг хамгаалах үзэл санааг утилитаризмын үзэл баримтлалыг үндэслэгч Иеремия

Бентам (1748-1832) нилээд гүнзгийрүүлэн хөгжүүлсэн. Утилитаризмын гол үзэл баримтлал нь аль болох олон иргэнд дээд зэргийн аз жаргалтай амьдралыг бэлэглэж чадахуйц төр засаг, хууль бол хамгийн шилдэг нь байх болно гэдгийг чухалчилдаг оршино. Мөн хэвлэлийн эрх чөлөө бол жирийн иргэд аз жаргалтай болоход нөлөөлдөг чухал хэрэгслийн нэг мөн. Учир нь захиргаадалтын засаглалын эсрэг зогсож, олонхийн эрх ашгийг хамгаалсан хууль батлахад нөлөөлдөг, төрийн албаны үйл ажиллагаанд хяналт тавьж, нийгмийн амьдралын аливаа баримтыг ил тод болгоход чухал үүрэг гүйцэтгэдэг гэж үзсэн нь чөлөөт хэвлэлийн үүрэг зорилгын талаарх орчин үеийн үзэл баримтлалтай нилээд ойролцоо юм.

«Эрх чөлөөний тухай» хэмээх алдарт бүтээлийг зохиогч Жон Стюарт Миллийн үзсэнээр иргэдийн хооронд үзэл бодлыг чөлөөтэй солилцох нь үнэнд хүрэхэд тусалдаг байна. Ж. Милль бол үзэл бодлын мэтгэлцээний, өөрөөр хэлбэл санал солилцох, чөлөөт шүүмжлэл бол нийгмийн хөгжилд онцгой чухал гэдгийг гурван шатлал бүхий үндэслэлээр тайлбарлаж, ийм үзэл бодлын мэтгэлцээний явцад үнэн өөрийн байр суурийг улам бататгах болно гэдгийг онцлон тэмдэглэжээ.

1. Төр засаг зарим үзэл бодлыг «үнэнд үл нийцэх» шалтгаанаар авч хэлэлцэхгүй байгаа нь хэрэг дээрээ тэр үзэл бодол бодит амьдралын баримтуудтай нийцэж байгаагийн илэрхийлэл. Тиймээс үзэл бодлыг цагдан хянах явдал бол тэдний үнэн байх боломжийг хязгаарлаж буй хэрэг мөн.

2. Бүр худал (алдаа мадагтай) үзэл бодол ч тодорхой хэмжээний үнэний хувьтай байдаг. Тиймээс зөвхөн үзэл бодлын мэтгэлцээний явцад л үнэн илрэх бөгөөд үүнийг хэвлэлийн эрх чөлөөгүйгээр хэрэгжүүлэх боломжгүй юм.

3. Хэрэв үнэн үзэл бодол ямар нэгэн шүүмжлэлд өртөхгүй бол тодорхой

хугацааны дараа атгаг сэжиг болон хувирдаг. Тиймээс хэвлэл үнэний талд зогсдог, түүнийг хязгаарлах, цагдан хянах хэрэггүй гэж үзсэн байдаг.

Сонгодог либерализмын үндэс болсон энэ дүгнэлтийг АНУ-ыг үндэслэгчдийн болон дэлхийд анх удаа либерализмын зарчимд үндэслэгдсэн цорын ганц Үндсэн хуулийг зохиогчдын нэг Томас Жефферсон нэгтгэн дүгнэж, хэрэв нийгэм боловсролтой, мэдээлэлтэй байгаа нөхцөлд зарим нэг иргэн төөрөлдсөн ч иргэдийн ихэнх нь зайлшгүй зөв шийдвэр гаргах болно гэж үзжээ. Жефферсон засгийн газрын үүрэг нь хувь хүн өөрийнхөө зорилгыг чөлөөтэй биелүүлэх боломжийг бүрдүүлсэн нийгмийн тогтолцоог байгуулах, дэмжихэд орших бөгөөд боловсролын ба мэдээллийн чухал хэрэгслийн нэг бол хэвлэл мөн гэж үзэж байв.

Энэ бүхнээс үзэхэд хэвлэлээр дамжуулан өөрийнхөө үзэл бодлыг чөлөөтэй илэрхийлэх явдал бол олон нийтийн үзэл бодлыг төлөвшүүлэхэд нөлөөлөх, төр засгийн байгууллагуудын зүгээс зөрчил гаргах, эрх мэдлээ хэтрүүлэн хэрэглэхийн эсрэг зогсох, хяналт тавих хэрэгсэл болдог онцлогтой юм. Эртний либерал үзэлтнүүд өөрсдийн үндэслэл, дүгнэлтийн хувьд тодорхой хэмжээгээр ялгаатай боловч хамгийн гол нь бие даасан чөлөөт хэвлэл төр засгийн зүгээс үзүүлэх дарангуйллаас хамгаалах баталгаа мөн гэдгийг бүгдээрээ санал нэгтэй хүлээн зөвшөөрдөг.

Хэвлэлийн эрх чөлөөний төлөө тэмцэл анхны ардчилсан орон болох Англи, АНУ-д хэдэн зууны туршид үргэлжилсэн түүхтэй. 1689 онд батлагдсан Английн Эрхийн тухай Билльд хэвлэлийн тухай нэг ч үг ороогүй. XVIII зууны 30-70-аад оны үед засгийн газрын үйл ажиллагаа, парламентын мэтгэлцээний тухай олон нийтэд хэвлэлийн (сонин, сэтгүүлийн) мэдээлэх эрхийн тухай, өөрөөр хэлбэл иргэдийн «мэдэх эрх»-ийг хэрэгжүүлэхийн төлөө маргаан нилээд эрчимтэй өрнөсөн

байдаг. XVIII зууны 30-аад оны үеэс парламентын үйл ажиллагааг «нээлттэй» болгох, өөрөөр хэлбэл парламентын үйл ажиллагааны нууцыг ил болгохыг хориглох тухай хуулийг хүчингүй болгохын төлөө тэмцлийг өөрийн эрхлэн гаргадаг «Gentlemen's magazine» сэтгүүлд Парламентын үйл ажиллагааны тухай нийтэлсэний төлөө хэд хэдэн удаа шоронд хоригдож байсан Лондоны хэвлэн нийтлэгч Эдуард Кейв эхэлдэг. Кейв Лилипут хэмээх орныг санаанаас зохиож, парламентын бүх гишүүдэд зохиомол, гэхдээ мэдэгдэхээр нэр өгч, «Лилипутийн сенат дахь шүүмжлэл» нэртэй цуврал сурвалжлага нийтэлсэн нь хууль хяналтынхны хараанд өртөөгүй өнгөрчээ.

XVIII зууны 60-аад оноос энэ тэмцэлд «North Britain» сониныг хэвлэн нийтлэгч Жон Вилкс оролцож, Лондоны ядуучуудыг тэмцэлд татан оролцуулсан ажээ. Энэ бүхний үр дүнд 1771 оноос парламент Английн парламентын хоёр танхимын аль алины хэлэлцүүлэг, шүүмжлэлийг хэвлэл мэдээлэх эрхтэй гэдгийг хүлээн зөвшөөрсөн юм. Энэ бол тогтмол хэвлэл төр засгийг ялж чадсан анхны тохиолдол байсан бөгөөд засгийн газрын үйл ажиллагааг мэдээлдэг, шүүмжилдэг замаар «засаглал»-ын үүргийг тодорхой хэмжээгээр гүйцэтгэж эхэлсэн гэж хэлж болно.

Олон нийтийн үзэл бодлын индэр болсон хэвлэлийн хүч, боломжийг хүлээн зөвшөөрөхөд ленд-лорд, тариачид, жижиг үйлдвэрлэгчдийн хамт «дөрөв дэх засаглал» буюу «дөрөв дэх давхарга» хэмээх ойлголт үүссэн явдал чухал нөлөө үзүүлсэн. Энэ нэр томъёог анх косерватизмын «эцэг» гэж нэрлэгддэг Английн нэрт улс төрийн сэтгэгч Эдмунд Бёрк (1729-1797) хэрэглэсэн байдаг. Тухайд үед энэ тэр томъёо сонин хэвлэлийн төр засаг болон нийгэмд бүхэлд нь үзүүлэх нөлөөллийн хэмжээг тодорхойлж байжээ.

Эрхийн тухай Америкийн Билль (Bill of Rights) буюу Америкийн Үндсэн

хуульд 1789 онд оруулж 1791 оны 12-р сарын 15-нд баталсан анхны 10 нэмэлтэд засгийн газарт харьцах сонин хэвлэлийн эрхийн тухай маш тодорхой тусгасан байдаг. Тухайлбал, алдарт Нэгдүгээр нэмэлтэд: «Шашны асуудлыг хөндсөн буюу чөлөөтэй шүтэж бишрэхийг хориглосон, аль эсвэл үг хэлэх, хэвлэн нийтлэх хийгээд ард олон санал гомдлоо илэрхийлсэн өргөх бичиг барин засгийн газарт хандаж, тайван жагсаал хийх эрхийг нь хязгаарласан хуулийг Конгресс гаргах ёсгүй» гэж тодорхойлжээ. Билль үгийн, хэвлэлийн, хурал цуглааны болон шашин шүтэх эрх чөлөөг хувь хүний, эд хөрөнгийн, захидлын халдашгүй байдалтай эн зэрэгцэх ойлголт гэж тодорхойлсон бөгөөд өнөөдөр хүртэл ардчилсан нийгэм дэх мэдээллийн үйл ажиллагааны баталгаа гэж үздэг. Судлаачдын байнга иш татдаг Абрам Линкольны «Ардчилал гэдэг бол засгийн газар нь ард түмнийх байх агаад, түүнийг ард түмэн өөрсдөө эмхлэн байгуулж, эрхлэн хөтөлж улмаар засгийн газраас ард түмний тусын тулд үйлчилнэ гэсэн үг» гэсэн алдарт томъёоллын утга учир нь чухам үүнд оршдог юм.

Эрхийн тухай Билль АНУ-ын Конгресст үг хэлэх болон хэвлэлийн эрх чөлөөг хязгаарласан хууль гаргахыг хориглох замаар хэвлэлийн нийгмийн тодорхой нэг «давхарга» болох нийгмийн статусыг бэхжүүлсэн бөгөөд энэ нь гүйцэтгэх, хууль тогтоох, шүүх засаглалын хамт «дөрөв дэх» засаглалын үүргийг гүйцэтгэх эрхийг баталгаажуулсан билээ.

Энэ бүхнээс үзэхэд ХVIII зууны дунд үеэс анхны Олон нийтийн мэдээллийн хэрэгслийн нэг болох сонин хэвлэл үгийн эрх чөлөө буюу мэдэх, үг хэлэх эрхийн төлөө төр засгийн эсрэг ширүүн тэмцэх замаар нийгмийн томоохон үүргийг гүйцэтгэж байжээ. Тиймээс «дөрөв дэх засаглал»-ын тухай үзэл санаа бол либертарын үеийн сонин хэвлэлийн буюу бүр тодруулж хэлбэл,

эртний ардчилсан нийгмийн хэвлэлийн мөн чанар, үүргийн тухай төсөөллөөс урган гарчээ. Энэхүү үгийн эрх чөлөөний зарчим болон түүнийг хэрэгжүүлэхийн төлөө тэмцэл бол төр ба нийгмийн хоорондох зөрчил, тэдний хүчний харьцаа, түүний түшиг тулгуур болсон тухайн үеийн сонин хэвлэлийн онцлогийг тодорхойлоход чухал үүрэгтэй юм.

«Мэдэх эрх» болох хэвлэл мэдээллийн эрх чөлөөний үзэл санаа хожим үүсч бий болсон мэдээлэл дамжуулах шинэ технологийн хэрэгслүүдийг ч тодорхой хэмжээгээр хамарч, энэ асуудал хөгжингүй орнуудын олон нийтийн мэдээллийн харилцааны үйл ажиллагааны хэм хэмжээний үндэс болсон маргаан, мэтгэлцээний төвд байсаар байна. Ер нь судалгааны бүтээлүүдээс үзэхэд түүхэн хөгжлийн явцад төр засаг ОНМХ-ийн ардчилсан нийгэмд гүйцэтгэх үүрэг, ач холбогдол, үр нөлөөг хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүй байдалд хүрчээ. Энэ байдал XIX зууны дунд үе буюу засаглалын, мөн олон нийтийн мэдээллийн тогтолцоонд глобаль шинжтэй өөрчлөлтүүд гарах хүртэл үргэлжилсэн юм.

Сүүлийн хориод жилд ганцаараа ноёрхож байсан «бодлогыг мэдээлэл-жүүлэх» ойлголт «мэдээллийг бодлого-жуулах» ойлголтын хамт нэвтэрч эхэлсэн. Энэ хоёр ойлголтын аль аль нь ОНМХ болон улс төрийн бодлогын, юуны өмнө улс төрийн засаглалын хооронд бий болсон шинэ хандлагын явцад үүссэн ОНМХ-ийн шинж чанар, нөлөөлөлтэй холбоотой гарсан бодит өөрчлөлтүүдийг илэрхийлдэг онцлогтой. Энэ асуудлыг судлахын өмнө зарим нэр томъёоны утга, агуулгын талаар арай дэлгэрүүлж авч үзэх шаардлагатай бөгөөд ялангуяа засаглалын тухай ойлголтод илүү их анхаарал хандуулах нь зүйд нийцнэ.

Орчин үед засгийн тухай ойлголтыг эерэг ба сөрөг талаас нь тайлбарлах хоёр гол хандлага байдаг. Сөрөг хандлага нь засгийг хүчирхийлэл,

дарангуйлал буюу шударга бус төрийн илэрхийлдэг бол эерэг хандлагын хүрээнд засаг гэдгийг хууль ёсны удирдлага, нэр хүнд, манлайлагчийг хүлээн зөвшөрөх, нөлөөлөл гэж ойлгодог байна. Энэ утгаар авч үзвэл засгийг ашиг сонирхлын зохицол, бүлгийн эв санааны нэгдэлтэй холбон ойлгож болно.

Хэрэв сөрөг хандлага XII зууны үеийн төр засагт хандах хандлагын шинж чанарыг илэрхийлдэг бол ардчилсан нийгэмд эерэг хандлага голлодог онцлогтой юм. Үүнтэй холбоотой засаглалын үзэл баримтлалыг ч ангилж үзсэн байдаг. Эхний хэв маягт XIX зууны эцэс, XX зууны эхний үеийн нэрт социологич Макс Веберийн засаглалын тухай сонгодог тодорхойлолтыг хамруулж болно. Тэрбээр засаглал бол «тодорхой нийгмийн харилцааны дотор, шаардлагатай тохиолдолд эсэргүүцлийг сөрж байж өөрийн санаа зоргийг хэрэгжүүлэх аливаа боломж»⁴ буюу өөрийн санаа зоригийг тулган хүлээлгэх явдал юм. Вебер засаглалыг «нийгмийн хувьд хэврэг», учир нь засаглал хэзээ ч, хаана ч байдаг, харин хамгийн наад зах нь хоёр ойлголтыг өөртөө агуулдаг гэдгийг тэмдэглэж, төрийн хувьд засаглал хэмээх нэр томъёо «захирагдах боломжийг олохыг» илэрхийлдэг «ноёрхол» гэсэн үг. Харин засаглал улс төрийн бодлогыг үндэс суурийг бүрдүүлж, янз бүрийн ашиг сонирхол бүхий бүлэглэлүүдийн хувьд зайлшгүй биелүүлэх шаардлагатай шийдвэр гаргах, түүнийг хэрэгжүүлэх үйл явц юм. Веберийн тодорхойлсноор ямар ч засаглалын хувьд эрх зүйн хэм хэмжээнд үйл

ажиллагаа явуулах, иргэд засаглал хууль ёсны гэдгийг хүлээн зөвшөөрөх гэсэн хоёр гол шинжийг агуулдаг байна. Дээрх үндэслэлээс үзэхэд хэдийгээр засаглал нь албадлагын шинжтэй гэдгийг илэрхийлж байгаа боловч түүнийг олон нийттэй харилцахгүйгээр хэрэгжүүлэх, оршин тогтнох боломжгүй гэсэн санаа нэвт шингэснийг амархан ажиглаж болно. Өөрөөр хэлбэл, ард түмэнтэй харилцаа холбоогүй, тэдний дэмжлэгийг авч чадаа-

гүй засаглал оршин тогтнох боломжгүй юм. Орчин үеийн социологийн сонгодог гэж нэрлэгддэг Т.Парсонсын хувьд засаглал гэдэг бол «нийгэм бүхэлдээ хүлээн зөвшөөрсөн зорилгод хүрэхийн тулд нийгмийн бүхий л нөөц боломжийг дайчлах чадвар мөн» юм. Нэрт улс төр судлаач Р.Нейштайдт ардчилсан засаглалын тухай үзэл санааг улам хөгжүүлж, за-

саглал бол орчин үеийн ардчилалд үндсэндээ итгэл үнэмшлийн засаглал мөн, учир нь итгэл үнэмшил бол байр суурийг ойртуулах үйл явц бөгөөд итгэл үнэмшлийн засаглал зөвшилцөлд хүрэхэд оршино гэж тодорхойлжээ.

Ер нь засаглалын тухай орчин үеийн үзэл баримтлалууд хоорондоо тодорхой хэмжээгээр ялгаатай боловч бараг бүгдээрээ засаглалын харилцааны асуудалд гол анхаарлаа төвлөрүүлсэн байдаг. Учир нь харилцааны (коммуникаци) явцад хүний хамтын нийгэмлэг үүсэж, төлөвшдөг онцлогтой. Энэ утгаар нь авч үзвэл ОНМХ бол төр засаг ба ард түмний хоорондох харилцааны хамгийн гол механизмын үүргийг гүйцэтгэдэг гэж хэлж болно. Олон түмэн зөвхөн ОНМХ-ийн тусламжтай-

«

*Орчин үед засгийн тухай
ойлголтыг эерэг ба сөрөг талаас
нь тайлбарлах хоёр гол хандлага
байдаг. Сөрөг хандлага нь засгийг
хүчирхийлэл, дарангуйлал буюу
шударга бус төрийн илэрхийлдэг
бол эерэг хандлагын хүрээнд засаг
гэдгийг хууль ёсны удирдлага, нэр
хүнд, манлайлагчийг хүлээн
зөвшөрөх, нөлөөлөл гэж ойлгодог.*

»

гаар түүнийг хэлэлцүүлэг, үзэл бодлын индэр болгох замаар төр засгийн удирдах төвшний шийдвэрүүдэд хяналт тавьж чадна. Мөн ОНМХ-ийн мэдээллийн ачаар засгийн газрын үйл ажиллагаа олны хүртээл болдог тул ОНМХ «төр засаг ба нийгэм» хэмээх харилцааны хамгийн тэргүүн эгнээнд тавигддаг. Нийгмийн ухамсар дахь ОНМХ ба засаглалын хоорондох энэхүү «уялдаа холбоо» нь орчин үеийн нийгэмд сэтгүүл зүйн бол «дөрөв дэх засаглал» мөн гэсэн үзэл баримтлалын үндэс болдог байна.

Иргэний нийгмийн институтын хөгжил, иргэдийн өөрийн ухамсар сул дорой байх тусам нийгэм төр засагт хяналт тавих хариуцлагыг ОНМХ-д хүлээлгэхийг чухалчилдаг нь түгээмэл юм.

Оросын сэтгүүл зүй судлаач И.Засурскийн тэмдэглэснээр Орост өмчлөлийн эрс өөрчлөлттээс шалтгаалан ОНМХ-үүд санхүү-үйлдвэрлэлийн бүлэглэлүүдийн өмчлөлд шилжиж, эдийн засгийн хувьд чадамжгүй болсон нь «дөрөв дэх засаглал»-ын тухай үзэл баримтлал унтрахад хүрсэн. Өөрөөр хэлбэл, улс төрийн дарамт шахалтаас түрүүлж дээрх хүчин зүйл нөлөөлсөн ажээ. Судлаачийн ОНМХ «дөрөв дэх засаглал гэдэг харьцангуй ойлголт, учир нь ОНМХ-ийн зорилго нь засаглал болоход бус, олон нийтийн үзэл бодлыг илэрхийлэх, тусгахад оршино. ОНМХ бол засаглал биш, гэхдээ ОНМХ-гүйгээр төр засаг ажиллаж чадахгүй»⁵ гэсэн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй.

Барууны орнуудад сэтгүүлчдийн мэргэжлийг харьцангуй чөлөөт мэргэжлийн тоонд оруулж, тэдний үйл ажиллагааны олон нийтийг хамрах шинжийг харгалзан сэтгүүл зүйн нийгмийн үүргийг тайлбарлах дөрвөн гол хандлага ажиглагдаж байна.

Мэргэжлийн сэтгүүл зүйн үүргийн нэг дэх загварыг ерөнхийдөө «дөрөв дэх засаглал»-ын үүрэг гэж ойлгож болно. Энэ нь юуны өмнө сэтгүүлчдийн

нийгэмлэгийг нийгмийг удирдахад оролцдог харьцангуй бие даасан нийгмийн институт гэж үздэгтэй холбоотой юм. Учир нь ийм нийгэмлэгийн гишүүд засаглалын бүх салбарт тодорхой үүрэг гүйцэтгэдэг. Мөн ийм засаглалыг ардчиллын дүрэм журмын дагуу хэн ч сонгохгүй, хэн ч хянахгүй, зөвхөн олон нийтийн хэрэгцээ шаардлага болон тогтсон хууль эрхийн актад захирагдах болно. Энэ утгаараа сэтгүүл зүй нийгмийн санаа бодолд шууд ба дам нөлөө үзүүлдэг засаглалын харьцангуй бие даасан эх сурвалж мөн. Ялангуяа хууль тогтоох, гүйцэтгэх засаглалын байгууллагууд, засгийн газрын төлөөлөгчдийн явуулсан кампанит ажлуудын явцад олон нийтийн санаа бодлоор дамжуулж сонгуулийн дүнд нөлөөлөх явдал түгээмэл байдаг.

Сэтгүүлчид заримдаа нийгэмд гүйцэтгэх өөрсдийн үүрэг, боломжийг хэтрүүлэн үнэлж, «дөрөв дэх засаглал» гэдгийг шууд утгаар нь үнэлэх явдал түгээмэл юм. Энэ нь Mass Media-г засгийн газрын хамтран зүтгэгч, дуу хоолой, эсвэл засгийн газрын үйл ажиллагааг хянадаг «сөрөг хүчний» үүргийг гүйцэтгэгч, түүний эсрэг тэмцэгч гэсэн утгаар ойлгоход нөлөөлдөг. Ийм хандлага засгийн газар, нийгмийн институт болон иргэний нийгмийн хөгжилд сөрөг нөлөө үзүүлж, тэдний хооронд нэг ёсны нийгмийн зөвшилцөл байхгүй байгааг харуулдаг онцлогтой.

Хоёр дахь загвар бол нийгмийн төлөө үйлчилдэг сэтгүүл зүйн загвар бөгөөд ОНМХ-ийг тодорхой нэг бүлэг хүмүүсийн иргэний эрхийг хамгаалах зэвсэг, иргэний нийгмийн бүхий л бүтэц, нэгжийн эрх ашгийг илэрхийлэх хэрэгсэл гэж үздэг байна. Иргэний нийгмийн нэгжид үйлдвэрчний, бизнесийн, хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах холбоод, нийгэмлэгүүд, соёлын, шашны байгууллагууд, янз бүрийн хөдөлгөөнүүд, зах зээлийн институтууд, олон нийтийн өөрөө удирдах зэрэг байгууллагууд, эмэгтэйчүүдийн,

залуучуудын, буяны зэрэг байгууллагууд багтдаг. ОНМХ мэдээлэл, харилцааны хэрэгслийн хувьд хүмүүст өөрсдийн ашиг сонирхлыг ухааран ойлгоход туслахын зэрэгцээ төр засаг энэхүү ашиг сонирхол, эрхийг хэрэгжүүлэх боломжоор хангаж буй эсэхэд хяналт тавих боломж олгодог.

Гурав дахь загвар бол цэвэр мэдээллийн загвар бөгөөд түүний үндсийг «баримт бол өөрөө өөрийгөө илэрхийлдэг» гэсэн утга санаа бүрдүүлдэг. Сэтгүүлчийн гол зорилго нь ямар ч үнэлэлт дүгнэлтгүй мэдээлэх, өөрөөр хэлбэл сэтгүүлч өөрийнхөө иргэний байр сууринаас татгалзаж, цэвэр мэдээлэгч болон хувирахад оршино. Гэхдээ энэ загварыг амьдралд хэрэгжүүлэхэд багагүй бэрхшээл тулгардаг нь ойлгомжтой. Учир нь ямар ч үнэлэлтгүй цэвэр мэдээлэл практикт ховор тааралддаг. Ямар ч тайлбарын явцад нийгмийн харилцааны онцлогоос шалтгаалан үнэлэлт тодорхой хэмжээгээр оршдог. Үүнээс гадна цэвэр мэдээлэл дамжуулах боломж хязгаарлагдмал байдаг нь ОНМХ өөрөө нийгмийн бусад институтын нэгэн адил нийгмийн харилцаанд оршиж, нийгмийн амьдралын янз бүрийн илрэл, нөлөөг агуулж байдагтай холбоотой юм.

Дөрөв дэх загвар бол дундыг баримтлагч, мэдээлэл дамжуулагчийн үүргийг гүйцэтгэдэг сэтгүүл зүйн загвар мөн. Өөрөөр хэлбэл, ОНМХ бол нийгэм дэх хүчнүүдийн тэнцвэрт байдлыг хангах зорилгоор олон нийттэй байнга яриа өрнүүлдэг, зохион байгуулдаг нэг ёсны өвөрмөц «талбар» болон хувирдаг гэсэн үг юм. Энэ үзэл баримтлал нь ОНМХ нийгэмд засаглалын үүргийг гүйцэтгэхийг гол болгохгүй, харин нийгмийн үйл явцын нэг чухал элемент болоход нөлөөлдөг онцлогтой. Гэхдээ орчин үед засаглалын нэг гол шинж нь олон нийтийн харилцаа гэдгийг иш үндэс болговол мэдээлэл дамжуулагчийн үүргийг гүйцэтгэж буй ОНМХ-ийн энэ загвар нь ч «засаглалын загвар» мөн гэдгийг

хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Харин энэ бол сэтгүүлчдийн хэлдэг, ойлгодог «дөрөв дэх засаглал» биш гэдэг нь тодорхой. Ер нь орчин үед «дөрөв дэх засаглал»-ын талаарх уламжлалт ойлголтыг эргэж харах, асуудалд арай өөр өнцгөөс хандах шаардлага тулгарч байна. Учир нь нэг талаар, ОНМХ-ийн боломжийг хэт хэтрүүлэн үнэлсэн байдаг, нөгөө талаар энэ нь сэтгүүл зүйн засаг төр, янз бүрийн бүлэглэлүүд, эдийн засгийн болон бусад ашиг сонирхлоос хамааралтай гэдгийг бүрхэгдүүлэх болно. Тиймээс орчин үеийн сэтгүүл зүйн үүргийн тухай асуултад хариулахын тулд юуны өмнө уламжлалт саад бэрхшээл болох ОНМХ-ийн үйл ажиллагаанд төр засгийн зүгээс оролцох явдлаас гадна хувийн хэвшлийн салбар дахь хэвлэл мэдээллийн хэрэгслийн ямар ч хяналтгүй өсөлт, эрчимтэй явагдаж байгаа төвлөрөлтэй холбоотой асуудлыг харгалзан үзэх шаардлага тулгарч байна.

Орчин үед сэтгүүл зүйн «дөрөв дэх засаглал»-тай холбоотой нөхцөл байдал эрс өөрчлөгдсөн бөгөөд энэ нь олон хүчин зүйлтэй холбоотой юм. Тэдний дотроос хоёр хүчин зүйл онцгой байр эзэлдэг. Энэ бол, нэгдүгээрт, технологийн хөгжил дэвшлийн үр дүнд олон түмэн өөрийн гэсэн дуу хоолойтой болоход хүргэсэн. Ийм дуу хоолойг үл хайхрах боломжгүй. Учир нь зохиогчоос хэрэглэгч рүү чиглэсэн уламжлалт нэг талын урсгалаас эрс өөр гэдэг нь тодорхой юм. Хоёрдугаарт, сэтгүүлчид өөрсдийгөө зөвхөн «баримтыг ажиглагч» бус мэдээллийн «утга санааг зохиогчид» гэж үздэг учраас ОНМХ «дөрөв дэх засаглал» биш, харин түүнээс дээд төвшний «засаглал»-ын үүргийг гүйцэтгэх ёстой гэж үздэг болжээ. Энэ нь орчин үед засаглалд гарч байгаа бодит өөрчлөлттэй ч холбоотой юм.

Хэдийгээр ОНМХ-ийн мэдээллийн засаглал нь хууль ёсных биш боловч олон нийтийн ухамсарт үзүүлэх нөлөө нь үнэлж баршгүй гэдэг нь тодорхой. Тиймээс төр засаг ОНМХ-ийг өөрсдийн

зорилгоор ашиглахын тулд янз бүрийн арга заль хэрэглэх тохиолдол элбэг гардаг. Төр засаг бодит байдлын үйл явцыг тогтмол хянах боломжгүй учраас «энэхүү бодит байдлыг удирдах үүргийг нийгэмд арай боловсронгуй мэдээллийн харилцааны бүтцийг бий болгож, олон нийтийн ухамсартай ажиллах боловсронгуй, үр нөлөөтэй технологийг нэвтрүүлж чадсан субъект л гүйцэтгэх болно»⁶. Орчин үеийн ардчилсан нийгмийн засаглалыг хуваах замаар ардчиллыг өргөжүүлэх үйл явцын нэг гол онцлог нь чухам үүнд оршино.

Английн социологич Энтони Гиденсийн үзсэнээр сүүлийн 200-300 жилийн турш (сонин үүссэн цагаас) мэдээллийн харилцааны үйл ажиллагааг зөвхөн төлөөллөөр дамжуулан зохион байгуулж ирсэн түүхтэй юм. Өөрөөр хэлбэл, хүмүүс өөрсдийн дуу хоолойг төлөөлөгчөөр, зөвхөн улс төрчид төдийгүй сэтгүүлчдээр дамжуулан хүргэдэг байв. Гэхдээ улс төрийн төлөөлөл болон сэтгүүл зүйн төлөөлөл хоёр хоорондоо зарчмын том ялгаатай юм.

Орчин үеийн нийгэмд сэтгүүл зүйн засаглалын хамгийн багаар бодоход дөрвөн гол эх сурвалжийг нэрлэж болно. Энэ бол:

1. Нэр хүндийн шинэ бодит дүр төрхийг бий болгох

2. Засаглалын төвлөрлийг сааруулах замаар түүний хүч, нөлөөг багасгах

3. Эрэн сурвалжлах сэтгүүл зүйн үндсэн арга болох илчлэн шүүмжлэх замаар төр засагт итгэх итгэлийг багасгах. Хэвлэл мэдээллийн даяаршлын үед илчлэн шүүмжлэх (expose) аргын үүрэг улам өсөн нэмэгдэж байгаа бөгөөд бүх төрлийн мэдээллийн хэрэгслийн хамгийн чухал зэвсэг болон хувирч байна.

4. Зах зээлийн нийгэмд ОНМХ зүүний чиглэлийн намын гүйцэтгэх үүрэгтэй ижил төстэй үүрэг зорилгыг гүйцэтгэж эхэлсэн. Гэхдээ үүнийг үзэл санааны хувьд бус агуулгын талаас нь

ойлгох нь чухал юм. Учир нь аливаа улс оронд зүүний чиглэлийг баримтлагчид үргэлж асуулт тавьж, илчлэн шүүмжилж ирсэн түүхтэй юм⁷.

Улс төрийг мэдээлэлжүүлэх, хэвлэл мэдээллийг улс төржүүлэх гэсэн нэгдмэл хоёр үйл явцыг нэгэн зэрэг агуулж өрнөсөн нийгмийн өөрчлөлт нь зөвхөн сэтгүүлчийн нийгэмд гүйцэтгэх үүргийг төдийгүй сэтгүүлчийн мэргэжлийн агуулгыг өөрчлөхөд нөлөөлж эхэлсэн. Орчин үед сэтгүүлчид мэдээллийг дамжуулагчид бус, утга санааг бүтээгчдийн үүргийг гүйцэтгэх замаар төр засгийн судасны цохилтыг мэдэрч, үйл ажиллагаанд хяналт тавьж, мэдээлж буй зүйл нь үнэн гэдэгт олон түмнийг итгүүлж чаддаг болсон. Үүгээр дамжуулж сэтгүүлч өөрт нь огт хамаагүй, нэг ёсны шинжээчийн үүргийг гүйцэтгэдэг болж, энэ нь өнөөдөр хүртэл нилээд түгээмэл байгаа «хэрэв энэ тухай сонин хэвлэлд бичиж, телевизээр дамжуулсан бол энэ нь үнэн байдаг»⁸ гэсэн уламжлалт үзэл бодлын ачаар амьдралд хэрэгждэг.

Бидний бодлоор судлаач Элиас Канеттигийн «Олон түмэн ба засаглал» хэмээх бүтээлд тодорхойлсон засаглалын үндсэн шинжүүд болон элементүүд тусгаж буй асуудлыг арай гүнзгий ойлгоход чухал үүрэгтэй юм. Э.Канетти өөрийн бүтээлд засаглалын хүчирхийлэл, нууцлал, шуурхай байдал, асуулт тавьж хариулт авах боломж, шүүх болон шийтгэх эрх, урамшуулах болон өршөөл үзүүлэх гэсэн зургаан шинжийг онцлог тэмдэглэсэн байдаг⁹.

Орчин үеийн нийгэмд засаг төр хүчирхийллээс улам бүр ангижирч, хяналт тавих, зөвшилцөх аргыг түгээмэл хэрэглэх болсныг амархан ажиглаж болно. Ардчилсан иргэний нийгэмд нууцлах, шуурхай байх зэрэг шинж нь мөн уламжлалт утгыг алдаж эхэлсэн. Харин бидний судалгааны хувьд засгийн газарт асуулт тавих хариулт авах, шүүх болон шийтгэх зэрэг шинж нь онцгой ач холбогдолтой юм. Нийгэм ардчилагдах тусам засаг төр энэ шинжүүдийг улам эрчимтэй алдаж

эхэлсэн бөгөөд чухам энэ шинжүүд засаглалын шинэ элементүүдийг төлөвшүүлэх үндэс болж хувирсан. Ардчилсан нийгэмд асуултад хариулахгүй байх боломж бол нууцыг хадгалах боломж гэсэн үг. Vice versa буюу хариулахгүй байх эрх бол нууцыг хадгалах эрхтэй гэдгийг илэрхийлнэ. Өөрөөр хэлбэл, асуултад хариулахгүй дуугүй байна гэдэг бол зөвхөн засаг төр өөрийгөө хамгаалж буй хэрэг бус, харин засаглалын тодорхой "хэсэг" нь хариулахгүй байгаа этгээдийн мэдэлд шилжиж байгаагийн илрэл юм. Гэхдээ орчин үед төр засагт асуулт тавих нилээд өргөн боломж, орон зай бий болж, ийм эрхийг гол төлөв сэтгүүлчид эдэлж, ОНМХ олон нийтийн үзэл бодлын индэр болон хувирч байна. Сэтгүүлчид ОНМХ-ийг ашиглан төр засагт өөрсдийн асуултыг тавих, эсвэл шууд ярилцлага хийх нь олон нийтийн өмнөөс хандах, тэднийг тодорхой хэмжээгээр төлөөлж байгаагийн илэрхийлэл гэж ойлгож болно. Сэтгүүлчдийн төр засагт тавьж байгаа асуултууд нь тодорхой хэм хэмжээнд баригдахгүй учир ямар нэгэн хязгаарлалт, цагдан хяналт тавигдахгүй. Харин цорын ганц хяналт бол сэтгүүлчийн ёс суртахууны хэм хэмжээ, хүн чанар, хувь хүний онцлог болдог. Тиймээс сэтгүүлчид ямар нэгэн хариуцлага хүлээдэггүй гэж хэлж болно. Нөгөө талаар сэтгүүлчид асуултаа олон нийтийн өмнө ил тавьдаг. Төрийн албан хаагч хуулиар хүлээсэн үүргийн дагуу асуултад хариулах ёстой. Энэ бол төр засаг өөрийнхөө *differentia specifica* буюу бусдаас ялгарах онцлогийг алдаж эхэлдэг гэсэн үг. Өөрөөр хэлбэл, засаглалаа хэрэгжүүлэх эрх нь хязгаарлагдах болно. Энэ тохиолдолд асуулт тавих, хариулт авах эрхээ эдэлж буй сэтгүүлчид засаглалын үүргийг тодорхой хэмжээгээр гүйцэтгэх бөгөөд эдэлж буй эрх нь төр засгаас хамаагүй хүчтэй, хамаагүй өргөн хүрээг хамрах онцлогтой юм. Орчин үед сэтгүүл зүйн «дөрөв дэх засаглал»-ын үүргийн

онцлог, бодит үр нөлөө нь чухал үүнд оршдог.

Сэтгүүл зүйн «засаглал»-ын үүрэгт нөлөөлөх өөр нэг чухал хүчин зүйл бол төр засгийн шүүх, шийтгэх эрхтэй холбоотой юм. Хэрэв хуучин энэ үүргийг төр засаг шууд утгаар хэрэгжүүлдэг байсан бол орчин үед сэтгүүл зүй энэ үүргийг илчлэн шүүмжлэх (*expose*), эрэн сурвалжлах аргаар хэрэгжүүлдэг нь түгээмэл болсон. Эрэн сурвалжлах сэтгүүл зүйн үндсэн арга болох илчлэн шүүмжлэх арга бол нийгмийн үзэл бодолд нөлөөлөхийн хувьд «дөрөв дэх засаглал»-ын хүчтэй хэрэгсэл мөн. Үүний үр дүнд улс төрийн засаглалын аливаа зүйлийг нууцлах боломжийг хязгаарлаж, зарим тохиолдолд тийм боломжийг бүрэн устгахад нөлөөлж болно. Үүний бодит жишээ болгон АНУ-ын Ерөнхийлөгчийг огцруулсан Уотгейтийн хэрэг, Филиппины Ерөнхийлөгч Жозеф Эстрадаг огцруулсан авлигын хэрэг, манай орны Молам-Айбексийн хууль бус гэрээ, Асгатын ордыг ашиглах талаар ОХУ-тай хийсэн гэрээ гэх мэт олон жишээ баримтыг дурдаж болно.

Орчин үед зөвхөн сэтгүүлчид төдийгүй улс төрчдийн хувьд ч онцгой үүрэг гүйцэтгэдэг засаглалын чухал нөөц боломж бол олон нийтийн үзэл бодол юм. Энэ бол шууд утгаараа ардчиллыг хэрэгжүүлэх үйл явцтай холбоотой. Учир нь иргэдийн төр засагт хандах хандлага нь олон нийтийн санаа бодол хэмээх ойлголтоор тодорхойлогдох бөгөөд орчин үеийн нийгэмд жагсаал цуглаан, санал асуулга, сонгууль, ажил хаялт зэрэг олон нийтийг хамарсан улс төрийн үйл ажиллагаагаар илэрдэг онцлогтой юм. Өдгөө олон нийтийн санал бодол ардчиллын оршин тогтох үндэс болж, төр засгийн өөрийн байр суурийг хадгалахад түшиглэх гол нөхцөл, боломж болдгоороо чухал ач холбогдолтой юм.

Засаглалын институт болон ОНМХ-ийн институт хоёр хэдийгээр өөр өөр

үүрэг зорилготой боловч орчин үед тэдний үйл ажиллагаанд ижил төстэй зүйл цөөнгүй ажиглагдах болсон. Улс төрийн засаглал зөвхөн нийгмийн бүх гишүүдийн хамтарсан, чиглэсэн зорилго бүхий үйл ажиллагаагаар дамжин хэрэгждэг. Улс төрд хэрэгжүүлж буй зорилгуудын олон нийтийг хамрах шинж нь хүмүүсийн үйл ажиллагааг чиглүүлэхэд шаардлагатай мэдээллээр хангах зорилго бүхий тусгай хэрэгслүүдийг ашиглахыг шаарддаг. Өөрөөр хэлбэл, хүмүүсийг нийтийг хамарсан үйл ажиллагаанд дайчлах, оролцуулахад нөлөөлдөг мэдээллээр хангах хэрэгсэл шаардлагатай гэсэн үг. Ийм үүргийг биелүүлдэг цорын ганц хэрэгсэл бол ОНМХ бөгөөд энэ нь түүний нийгмийн үзэл бодлыг бүрдүүлэх, иргэдийн санал бодлын индэр байх үүрэгтэй шууд холбоотой юм. Ийм үзэл бодлын индэр болох онцлог нь ОНМХ орчин үеийн улс төрийн үйл явцад онцгой үүрэг гүйцэтгэж, улс төрийн амьдралд хүчтэй нөлөө үзүүлэх боломжоор хангадаг байна. Үүний бодит жишээ бол сүүлийн үед бий болсон «улс төрийг мэдээлэлжүүлэх» хэмээх ойлголт юм. Энэ нэр томъёо бидний үгийн санд ороод удаагүй боловч өнөөдөр ардчилсан орнуудад өргөн хэрэглэгддэг болжээ. Түүнчлэн үүнийг эсрэгээр буюу хэвлэл мэдээллийн улс төржилт гэсэн утгаар бас хэрэглээд удаж байгааг дурдах хэрэгтэй. Мэдээж үүнийг шууд утгаар нь ойлгоход учир дутагдалтай. Учир нь ОНМХ-ийн улс төрийн үйл явцад нөлөөлөх нь засаглал биш, харин тодорхой хэрэгслийн үүргийг гүйцэтгэж буйн илрэл мөн. ОНМХ засаглалын харилцаанд хэдийгээр чухал үүрэг гүйцэтгэдэг боловч үүнийг засаглал биш, харин засаглалын хэрэгсэл гэсэн утгаар ойлгох нь чухал юм.

Энэ бүхнээс үзэхэд орчин үеийн олон нийтийн мэдээллийн харилцааны хэрэгслүүдийн нэг гол үүрэг нь мэдээллийн нийгмийн чухал хүчин зүйлүүдийн нэг болох

нийгмийн амьдралын өвөрмөц хүрээ — улс төрийн үйл ажиллагаанд нөлөөлөхөд оршино. Энэхүү шинэ нөхцөлд ОНМХ олон нийтийн үзэл бодол, дуу хоолой болох боломжийг ашиглах замаар засаглалын төлөөллийн үүргийг тодорхой төвшинд гүйцэтгэдэг. Гэхдээ ОНМХ олон нийтийн үзэл бодлыг ашиглан үйл явдлын урьдчилж төлөвлөсөн хувилбарыг засаг төрд тохиромжтой байдлаар өгч, олон нийтийг идэвхгүй ажиглагчийн эгнээнд шилжүүлдэг нь түгээмэл юм. Орчин үеийн нийгэмд ийм байдлаар олон нийтийг хамрах хандлага эсвэл олон нийтийг улс төрийн хүрээнээс гадуур үлдээхийг чухалчилдаг технократ хандлага гол байр эзэлж байна.

Ишлэл

¹ Thompson J. B. 1995. The Mass Media and Modernity. A Social Theory of the Media Stanford University Press, p. 46.

² Цит по книге: Черных А. 2007. Мир современных Масс Медиа. М., с. 250.

³ Мильтон Ж. 1907. О свободе печати. Речь к английскому парламенту (Ареопагитика). М., с. 4.

⁴ Weber M. 1972. Wirtschaft und Gesellschaft. J.C.B.Mohr (Paul Siebek).

⁵ Засурский И. И. 2001. Реконструкция России. Mass Media и политика в 90-е годы. М., с.124.

⁶ Дацок С. Аналитика СМИ — четвертая власть // "Русский журнал", 1998, 3 фев. / www.russ.ru/journal/media

⁷ Kaplan R. The Media and Medievalism / "Policy Review", 2006, №128 // www.policyreview.org

⁸ Huff D. 1954. How to lie with statistics. N.Y.: Norton, p. 183.

⁹ Каннетти Э. 1997. Массы и власть. М.: Ad Marginem, с. 308, 314, 320, 322.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Зулькафиль М. 2007. Орчин үеийн сэтгүүл зүй. УБ.

2. Зулькафиль М. 2010. Монголын олон нийтийн мэдээлэл: нэг намын үзэл суртлаас олон ургальч үзэл хүртэл. УБ.

3. Зулькафиль М. 2011. Ардчилсан нийгэм дэх сэтгүүл зүйн онол, практикийн асуудлууд // Монголын шилдэг нийтлэл, №31, УБ.

4. Варустин Л. Э. 1995. Пресса и власть. СПб.

5. Дацюк С. Аналитика СМИ — четвёртая власть // "Русский журнал", 1998, 3 фев. / www.russ.ru/journal/media

6. Засурский И. И. 2001. Реконструкция России. Mass Media и политика в 90-е годы. М.

7. Каннетти Э. 1997. Масса и власть. М.: Ad Marginem.

8. Милль Ж. 1882. О свободе // Милль Ж. Утилитарианизм. О свободе. 2-е изд. СПб.

9. Мильтон Ж. 1907. О свободе печати. Речь к английскому парламенту (Ареопагитика). М.

10. Черных А. 2007. Мир современных Масс Медиа. М.

11. Huff D. 1954. How to lie with statistics. N.Y.: Norton.

12. Kaplan R. The Media and Medievalism // "Policy Review", 2006, №128 // www.policyreview.org

13. Thompson J. B. 1995. The Mass Media and Modernity. A Social Theory of the Media Stanford University Press.

14. Weber M. 1972. Wirtschaft und Gesellschaft. J.C.B.Mohr (Paul Siebek).

Резюме

В статье автор, опираясь на выводы и концепции исследователей, а также на особенности развития современной независимой журналистики, анализирует понятие "четвертой власти". На основе анализа возникновения и формирования этого понятия автор приходит к выводу о том, что в современном обществе сложились четыре базовые интерпретации социальной функции журналистики, связанные с концепцией "четвертой власти" и раскрывает сущность этих интерпретаций. Также в статье автор выделяет такие основные источники власти журналистики, как создание новой реальности авторитета, децентрализация власти, снижение доверия к власти путем разоблачений, выполнять роль подобную той, какую играют левые партии.